

**“ҮҮРИЙН ТУЯА” РОМАН ДАХЬ
МОНГОЛ ХҮНИЙ ДҮР ТӨРХ**

Б.Сарантуяа *

Зохиолч Б.Ринченгийн уран бүтээлийн оргил нь түүх хувьсгалын сэдэвт “Үүрийн туяа” роман юм. Романы тэргүүн дэвтэр "Манжийн талхинд" /1951/, дэд дэвтэр "Гал усны гашуун зовлон" нэртэйгээр хэвлэгдэж, нэмэлт засвар хийсэн хоёрдахь удаагийн хэвлэл нь ардын хувьсгалын 50 жилийн ойгоор гарчээ. Уул роман орчин үеийн монголын уран зохиолын түүхнээ хүндтэй байр эзэлдэг бөгөөд орчин цагийн монгол романы анхны дээж, алтан хараацай нь болсон шилдэг бүтээл юм.

Зохиолч *"Миний бие жинхэнэ бодитой түүхийн материалыг уран сайхны аргаар боловсруулахыг бодсон учир уг үнэн байдлаас хазайлган элдэв уран зохиолоор зориг мэдэн чимэглэх зүрх хүрсэнгүй. Тэр учраас уг зохиолд гарсан хүмүүсийн арваны есөн хувийг нь чухамхүү бодитой нэрээр нь нэрлэсэн билээ"* гэж бичсэн байна.

Энэ роман эх орныхоо түүхэн амьдралыг өргөн дэлгэр гаргаж ард түмнийхээ тэмцлийн түүхийн урт удаан үеийг гүн гүнзгий дүрсэлсэн, нийгмийн олон анги давхаргын олон янзын төлөөлөгчдийн дүрийг бүтээж, танин мэдэх сурган хүмүүжүүлэх хүчтэй нөлөө бүхий болсон нь онцлог юм. /Монголын орчин үеийн уран зохиолын түүх., УХГ. УБ. 1989. 301-302 тал/

Аливаа хэлний үгийн сангийн үгс хичнээн баялаг боловч түүнийг эзэмшиж сурсан хүмүүсийн мэдлэг харьцангуй, өдөр тутмын тулга тойрсон цөөн хэдэн үгээр харилцаж сурсан тухай академич Ц.Дамдинсүрэн “Олон түмний мэддэг үгс нь далай мэт өргөн байтал нэгэнт бичиж дадсан гэдэг хэдхэн улигт үгээр хамаг утга бүхнийг багтаан бичихийг оролдох муу заншлын үлгэр нь зуун адуутай хүн нэг хоёр номхон морио үргэлж унаж, бусдыг ямагт салхи эдлүүлэн зэрлэг явуулах мэт буюу. Иймийн тул бичиг зохиолд аль болохоор элбэг баян үгийг хэрэглэж, оновчтой мэргэнээр найруулж, уншихад урамтай, ухахад мэдрэмжтэй болгохыг хичээвэл зохино. /Ц.Дамдинсүрэн., Монгол хэлбичгийн тухай УБ. 1957., 95 дугаар тал/ гэж тэмдэглэсэн байдаг. Үнэхээр бичиг ярианы хэлний аль алинд үгийг зөв сонгон хэрэглэх нь нэн чухал.

Энэ өгүүлэлд их эрдэмтэн “Үүрийн туяа” романдаа XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн монголчуудын гадаад овор дүр төрх, дотоод сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг хэрхэн нарийн гаргасны нь товч үзүүлэх гэсэн юм.

Үүрийн туяа романд /Б.Ринчен “Үүрийн туяа” УХГ УБ 1971/ нэгдүгээрт, хаад ноёд, лам хувраг, хар хамжлага, зарц, гэрлэсэн гэрлээгүй, хөгшин залуу, хүүхэд зэрэг олон

* МУИС-ийн МХСС-ийн Монгол хэлний тэнхим

анги давхаргын хүмүүсийн нүүр царай, нүд, хөмсөг, уруул, үс, гээг сахлыг яаж дүрсэлсэн байна вэ?

Хүний нүүр царайг:

Хүрэн- хүрэн царай, хүрэн улаан царай, хөрслөг хүрэн царай, эцэнгэр хүрэн нүүр

Улаан- Улаан царай, хүрэл улаан царай, бундгар улаан царай, улаан нүүр

Хөх- Хөх царай, бүдүүлэг хөдөх хөх царай, зэрлэг манга хөх царай, улцгар хөх царай

Шар- зэвхий шар царай, улцгар шар царай, цонхигор шар царай

Цагаан- цусгүй цанхигар цагаан царай, хохигор цагаан царай

үхширэн зэвхийрсэн царай, зэвхий царай, цагаан царай

Нүүр царайд нь хүний мөс, сэтгэл илэрсэн байдлаар нь:

өтөлж больсон царай, өтөлж шалхайсан нүүр, үрчгэр нүүр, овор ихтэй царай, угаамал царай, чавганц царай

-хөөрхөн царай, гоо сайхан царай, санаа амар сайхан царай, жавхлант сайхан царай, тэнүүн сайхан царай, тэнэгэр сайхан царай, тэнгэрийн үзэсгэлэнт нүүр

-төв царай, талбиун төв царай, нүдэнд дулаан царай, амирлангуй сайхан царай

-хатан зоригт царай, сэргэлэн эрэлхэг царай

-мангуу шиг царай, мунхаг шиг царай

-харгис царай, харгис муухай хүйтэн царай, догшин царай, албаны хүйтэн царай гэж дүрсэлжээ.

Бид өдөр тутмын яриандаа алаг нүд, том нүд, онигор нүд, торомгор нүд, мойл хар нүд, жартгай нүд гэхээс өөрөөр нэг их хэлж ярьдаггүй.

Романд нүдийг:

-хар нүд, мойл хар нүд, тас хар нүд, гялалзсан хар нүд, гялгар хар нүд, ажигч хурц нүд

-орос хүний нүдийг том хөх нүд, шилүүсний нүд, тунгалаг хөх нүд, цэнхэр нүд, цэнхэр бор нүд

-мөн галтай нүд, галтай сэргэлэн нүд, уртлаг торомгор нүд, билгүүн нүд

-хонхойн ширгэсэн нүд, гунигт том нүд, бүдэг нүд, сохойсон анигар нүд, сохгор нүд, үхсэн загасны булингартай нүд, хилэн бадарсан нүд, дорсгор шар нүд, улаан жартгай нүд, хэрсүү нүд гэж хүний нүд, нүдээр нь тэр хүний зан авир, хөгшин залуу, царайлаг буюу царай муутай эсэх, мөн сэтгэлийн хөдөлгөөнийг хэрхэн илэрхийлснийг харж болж байна.

Хөмсөг:

-хүр хорхой мэт үслэг хөмсөг, нарийн хар хөмсөг, өтгөн гэгчийн хөмсөг, сагсгар буурал хөмсөг, өтгөн хар хөмсөг, урт буурал хөмсөг

Сахал:

буурал- буурал сахал, буурал соёо сахал, сийрэг буурал сахал, урт буурал сахал, битүү мөнгөн сахал, уртлаг битүү мөнгөн сахал,

мөнгөн мэт гилэвгэнэх цагаан сахал,

-хирвээ хар сахал, өтгөн хар сахал, бяцхан ширвээ сахал, хирвэж зассан бяцхан сахал, шингэхэн соёо сахал, шар сахал

Уруул:

-чавга улаан уруул, тачаангуй зузаан уруул, хагарсан хуурай уруул, нарийн уруул

Үс гээг:

-мяндсан сайхан гээг, шодон буурал гээг, буурал гээг, хилэн хар үс, шар үс, дун цагаан үс

Шүд:

-хурц шүд, морины шүд шиг урт шар шүд, дун цагаан шүд, дорсгор шар шүд, урт дорсгор шүд гэж бичсэнээс ургуулаад тухайн үеийн монголчуудын тавьж байсан олон янзын сахал, мөн хүмүүсийн үс гээг, хөмсөг уруул, шүдийг зураач хүн бол зурахаар хүний нүдэнд үзэгдэж, сэтгэлд буухаар тод зуржээ.

Хоёрдугаарт, хүний сайхан муухайг гадаад төрх, нүүр царайгаар нь төдийгүй дотоод сэтгэлийн баялаг ертөнц сэтгэлийн хөдөлгөөний илрэлээр нь хэрхэн гаргасан байна вэ? Үүнд:

Инээх, инээмсэглэх:

-элгээ хөштөл инээх, нулимс гартал инээх, элэглэн инээх, түсхийтэл инээх, нүд анисхийн инээх, маасайн инээх, тачигнатал инээх, таашаан инээх, зусардан инээх, билбүүрдэн инээх, яс шижигнэм хүйтнээр инээх, хүйтнээр тачигнан инээх, шүдээ ярзайн инээх, гашуунаа инээмсэглэх, дурамжгүйхэн инээмсэглэх, царайчлан өрөвдмөөр инээмсэглэх, таваа ханан инээмсэглэх, битүүхэн инээмсэглэх, бахархан инээмсэглэх, эелдгээр инээмсэглэх, сулханаар инээвхийлэх, найрсгаар инээмсрэх

Баярлах, баярлуулах:

магнайгаа хагартал баярлах, хэнхдэг дүүрэн баярлах, сэтгэл зүрхнээсээ баярлах, тэсэлгүй баярлах, олзшаан баярлах, битүүгээр баярлах, зүрх орж баярлах, баярын магнай тэнийх, дээлдээ багтахгүй бахдах, элэг зүрхий нь халуу оргитол жигнэх, сүүлээ дээш сөхөх /муу утгаар/, чихий минь баярлуулах

Харах:

энхрийлэн харах, уяран харах, бахархан харах, сайхнаар мишээн харах, сүрхий харах, бахдан харах, сэм харах, овтон харах, тавархан харах, зусардан харах, атаархан харах, хялсхийн харах, хялан хялан харах, нүд шилжилгүй ширтэн харах, бишүүрхэхсийн ширтэх, жармайж харах, ширвэн харах, ширтэлхийлэн харах

Айх, айлгах:

-зүрх алдах, зүс шороон өнгөтэй болж ухаан амигүй айх, үнсэн хөх болох, сүүлээ хавчих, айн ширвээдэх, зүрх түгших, зүрх үхэх, ухаан алдтал айх, сүг сүнсгүй айх, тэсгэлгүй айх, айн хэлмэх, нүд далдирах, нүд хальтрах, ясны нь хөлс гартал сандрах, мэхийрэн хулчийх, зүрхний нь хий дарагдах, хэл нь ээдрэх, зүрх эмтрэх, зүрхийг амаараа үхүүлэх

Хүний зан ааш:

-даруу зан, номхон даруу зан, нам зан, сайхан зан ааль, дөлгөөн зөөлөн авир,

-их зан, дээгүүр их зан, давлиун их зан, ихэрхэг зан, хэгжүүн их зан, түргэн зан, хэвцэг хэвлүүн зан, эршүүд зан, эрх танхил зан, наалинхайлах зан гэжээ.

Хэлний найруулга зүйд адилтгал зүйрлэлийг оновчтой хэрэглэхийн тулд жишиж байгаа хоёр зүйлийн төсөөтэй талыг зөв сонгох, тухайн зүйлийн хамгийн гол буюу түгээмэл шинжийг онцлон үзэх, олон үеийн турш хэрэглэсээр ирсэн уламжлалыг харгалзах, хэн бүхэнд ойлгомжтой байх, хүний сэтгэлийг хөдлөхүйц уран дүрслэх зэрэг чанарыг шилж сонгох хэрэгтэй байдаг. /Ц.Сүхбаатар Орчин цагийн монгол хэлний найруулга зүй. УБ.,1988. 12 дугаар тал/

Энэ романд ухагдахуунаар дамжуулан бодит ахуйг тусгадаг үгийн тогтмол агуулга болсон уг үгийн үгийн сангийн утгыг үнэхээр нарийн нягталж онож сонгон, эх хэлнийхээ урнаар дүрслэх чадлыг зохистой ашиглаж, яруу найруулсны хувьд дууриалалтай болсон юм.

“Үүрийн туяа” романд монгол хүний шинж төрхийг тусгасныг тоймлон үзэхэд ийм байна. Тодорхой дүрийг жишээлэн гол баатруудын нэг Батбаярыг хэрхэн дүрслэснийг үзье.

Батбаярын гадаад төрх:

өргөн мөртэй, чийрэг сайхан биетэй, буурал соёо сахалтай сүлжсэн битүү хуузтай, урьд залуудаа аварга хүчтэй бөх явсан хүн /романы 18-р тал/

өндөр нуруутай /224-р тал/

дун цагаан үстэй буурал өвгөн Батбаяр /482-р тал/

наян нас хүрвч өвгөний бие тэнхлүүн ухаан саруул, байдал дүр маш жавхлантай, зүс царайд сайхан сэтгэлтэй байдал нь тодорхой /482-р тал/

цал буурал толгойтой, буурал соёо сахал, уртлаг битүү мөнгөн сахалтай /484-р тал/

уд модны навч адил уртлаг нүд /486-р тал/

өргөн гэгчийн дал мөртэй, мөнгөн мэт гилэвгэнэх цагаан сахалтай, өндөр өвгөн Батбаяр /540-р тал/

Батбаярын тухай хүмүүсийн өгүүлэх нь:

Зохиолч: монгол бичиг судар нэлээд үзсэн өвгөн малчин Батбаяр /42/ шударга чигч Батбаяртай танилцаад /54/

Радловын газарч: өвгөн хүнээр их сайн хүн /41/

Сүрэн Ширчинд: Батбаяр байвал чи бид хоёр арай иймд хүрэхгүй юм сан даа. Жамба тэр шударга чигч өвгөнөөс айдаг /162/

Ширчин: сайхан санаатай Батбаяр авгай /166/

Цэрэн: ном их үздэг, юм их мэддэг хүн /167/

Ширчин: Батбаяр өвгөний зааж өгсөн бөхийн арга хэрэглэн /229/

Тансаг: маш төв жавхлантай Батбаяр /484/

Ардууд: юмыг их үзсэн хашир өвгөн Батбаярын суух хөдлөх байдал талбиун тэнэгэр, ихэмсэг жавхлантай /484/ гэж бичсэн байна.

Энэ роман 200 орчим зүйр цэцэн үг байгаагаас *өвгөн Батбаярын*

“Аргат хүн арав хоног” Сүрэнд хэлж байна /зохиолын 27-р тал/

“Тэнгэрт хэлье тэнгэр хол” өөрийн бодол /46/

“Өглөгт их бага гэдэггүй” Бадарчинд /122/

“Эзэн хичээвэл аз хичээдэг” Жамбад /123/

“Айл хүний амь нэг” Жамбад /123/

“Үхрийн чихэнд ус ч хийсэн тос ч хийсэн адилхан сэгсэрнэ”

Жамбад /123/

“Уулсыг цас дарж намайг нас дарж, чамайг мунхаг чинь дарж дээ”

Жамбад /123/

“Эрхийн чинээ биетэй, эр хонгор дуутай” Петровнад /150/

Ханан гэр холдож, хадан гэр ойртоод Иван /156/

“Гарын бөх ганц хүнд, цээжийн бөх цэргийн хүнд Иванд /156/

“Төрийн төлөө оготно боомилж үхэх Иванд /246/

“Тэнгэрт хэлье-тэнгэр хол

Газарт хэлье-газар хол” Иванд /247/

“Амны билгээс ашдын билэг” хөдөөний өвгөнд /391/

“Нэгэн үхрийн эвэр цохивол мянган үхрийн эвэр доргидог

Хүүхдүүдэд /509/

“Ерөөлийн далд муулрын ил нь дээр” Хүүхдүүдэд /536/

“Төр төмөр нүүртэй “ Хүүхдүүдэд /536/

“Эд торгоор биеэ чимснээс

Эрдэм номоор биеэ чимсэн нь дээр” Хүүхдүүдэд /544/

хэмээн сургамжлан хэлж байдаг нь үнэн үгтэй, төв шударга, эрдэм номыг эрхэмлэн дээдэлдэг уг хүний зан төрхийн бас нэг илрэл болж байна.

Романы өвгөн Батбаярын дүр билгүүн номч их зохиолчтой өөртэй нь их адилхан санагдлаа. Оросын сэтгүүлч Виталий Озеров дурдатгалдаа Б.Ринчен академичтай анх уулзсан тухайгаа “...нийслэлийн Улаанбаатар зочид буудлын өрөөний хаалгыг нэг хүн хэдий аяархан боловч нөр шургуу тогшив. Нэлээд содон хүн орж ирэв. Түүнийг үзвэл урт цагаан үстэй, мөн урт цагаан соён сахалтай, хүрэн бор царайтай, өндөр сайхан эр агаад насаар өвгөжөөр хүн атал ер бусын хөнгөхөн хүн байв. Гоё хөх дээл өмсөж, үндэсний хээ угалз бүхий мөнгөн тоногтой өргөн суран бүс бүсэлжээ.

Ринчен талын малчин янзтай, хол хол намуухан алхан орж ирээд монгол хүний ёсоор гар зөрүүлэн золгох янзтай хоёр гараа их л хүндтэй дэлгэснээ баруун гараар миний гарыг эрмэг чанга атгаж мэндлэв. Хөдөлгөөн алгуур тайван, юм ярих нь мөн итгэл төгс боловч дуу нь төдийлөн чанга биш нам, монголын уран үлгэрч юм уу, европын их эрдэмтэй профессор, хүний адил тун чадамгай ярьж байв. Энхрий тал нутагтайгаа хэзээд хамт байдаг энэ хүн бол хэлний шинжлэлийн том эрдэмтэн, профессор, академич хүн юм. /Оросын сэтгүүлч Виталий Озеровын “Идэвхтэй үйл чадалтай санаа” /Гадаадынхан монголын уран зохиолын тухай/ УХГ., 1977, 155-156 дугаар тал/ гэж бичсэнийг сонирхуулан дурдъя.

“Үүрийн туяа” роман дахь монгол хүний нүүр царай, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн дээрх хэсгүүдийг авч бичсэний эцэст нь манай ард түмний урлаг, соёлын их эрдэнэсийн сан, манай нэрт зохиолчдын зохиол бүтээлүүдэд

1. Монгол хүн ямар хүнийг сайхан гэдэг вэ?

2. Ямар нүүр царай, хөмсөг, нүд ...гэх мэтээр монгол хүний гоо сайхны хүслэнг тодруулах

3. Монгол хүн хүнийг, түүний эрхтнийг шинжлэхдээ юуг гол болгодог юутай адилтгадаг вэ?

4. Монгол хүн юуг үзэн яддаг, юунд дургүй вэ? Үүнд:

а/ нүүр царай

б/ нүд,

в/ зан ааш

г/ инээд гэх мэт

5. Монгол эрийг шинжих заншил

6. Монгол бүсгүйн шинж төрхийг шинжих заншлыг судлах нь монгол ёс заншлаа сэргээх үйлсэд чухал юм. Энэ шинжийг тусгасан үгс нь монгол хэлний тайлбар толь, ойролцоо нэр, ижил нэр, эсрэг нэр, хэлцийн толь, найруулга зүйн толийн тайлбарыг баяжуулахад зайлшгүй хэрэгтэй болох юм.

Орчин үеийн монголын уран зохиолыг үндэслэгчдийн нэг Б.Ринчений “Үүрийн туяа” роман бол монгол романы түүхэнд гарсан нүүдэлчин малчны амьдралыг харуулсан анхны шилдэг бүтээл учраас нүүдэлчний сэтгэл зүй, гоо зүйн эрхэмлэл нь энд үнэнээр туссан байна.

РЕЗЮМЕ

Автор статьи анализируя исторический роман одного из крупнейших представителей современной монгольской литературы Бямбина Ринчена “Заря в степи” приходит к выводу, что подробно и детально описывает, как выражены внешний вид, душевное состояние монголов конца XIX -ого и начала XX вв.

Результат проделанных нами исследований показывает, что конкретно и точно отражены в названном романе характерные для монголов особенности внешнего вида, в частности что в романе находит яркое и четкое выражение внутренний мир монголов, их чувства, радость и горе, гнев и страх и другие.